

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СНАГ-2025/019/НА-СТА-ТЕЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:sambuunyamy@audit.gov.mn">sambuunyamy@audit.gov.mn</a> Санхүү,нийцлийн аудитын газрын захирал,Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261945 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:tsogbayara@audit.gov.mn">tsogbayara@audit.gov.mn</a> Ахлах аудитор Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:ariunjargalb@audit.gov.mn">ariunjargalb@audit.gov.mn</a> Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:usukhjargalg@audit.gov.mn">usukhjargalg@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,

Цахим шуудан: info@audit.gov.mn,

Цахим хуудас: www.audit.mn

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН  
ТАНАА

2025.04.25 № 1615

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 141,172.9 сая төгрөгийн зөрчил бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Харьяа 120 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлантай холбоотой нийт 121,840.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр тайлант онд хэрэгжиж дууссан нийт 21,119.8 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлт хангалтгүй;
- Монгол улсын 2014 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд тусгагдсан Олон улсын Найрамдал цогцолборын Усан спорт цогцолборын барилгын ажлын санхүүжилтийн 91.0 хувь буюу 16,540.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгосон ч ажил нь бүрэн дуусаагүй, зураг төсөл зохиогчийн зүгээс уг барилга нь зураг төсвийн дагуу баригдаагүй, чанарын шаардлага хангаагүй гэж дүгнэж зохиогчийн эрхийн

хяналтаас татгалзах санал ирүүлсэн зэргээс үзэхэд төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашиггүй зарцуулсан нь цаашид өртөг нэмэгдэх эрсдэлийг бий болгосон;

- Хөрөнгө оруулалтын зардлын санхүүгийн тайланд тусгагдсан 2018 онд үүссэн аж ахуйн нэгжээс авах 398.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.8, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 2 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1, 208 дугаар зүйлийн 208.1, 211 дүгээр зүйлийн 211.1, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын болон Засаг даргын нөөц сангаас 11,289.4 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 8,788.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,838.1 сая төгрөг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 3,344.5 сая төгрөгийн хандив тусламж, нийт 28,925.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 27,432.4 сая төгрөгийг зарцуулж, 1,493.1 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн.

Засгийн газрын 2024 оны 02 дугаар 28-ны өдрийн 82 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төв болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгохоор холбогдох журмыг шинэчлэн батлуулж, нийт 105.2 мянган төрийн албан хаагчид улсын төсвөөс 308,000.0 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн үйлчилгээ болгон олгохоор шийдвэрлэсний дагуу 1,303,997 хүүхдэд нийт 1,540,026.3 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон нь нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээний зардлын 66.9 хувийг эзэлж байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд улсын хэмжээнд зорилтот бүлгийн нийт 60,406 иргэн хамрагдсанаас 54 хувь буюу 32,652 эмэгтэй иргэн байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд нийт 668.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

## Бусад асуудлын хэсэг

Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын тайланд дараах байдлаар тайлагнасан байна. Тухайлбал: “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт 86.7 хувьтай, “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-ийн 21 арга хэмжээнээс 16 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, Засгийн газрын “2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилт, арга хэмжээний 2024 оны биелэлт 88.5 хувьтай байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, нэг хүүхдэд ногдох зардлын дундаж норматив, сум хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал, орон тоог батлуулж, орон нутагт 590, нийслэлд 337, улсын хэмжээнд нийт 833 хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан сум, хорооны түвшинд ажиллуулахаар 2025 оны төсөвт цалингийн санг батлуулсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	331,882,887.2	476,790,229.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,928,599.1	29,015,189.3
АВЛАГА	249,200,486.5	366,770,219.3
УРЬДЧИЛГАА	171,654.9	96,038.8
БАРАА МАТЕРИАЛ	9,299,699.6	12,130,140.7
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	55,282,447.1	68,778,641.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	152,999,940.8	202,617,741.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	152,999,940.8	202,617,741.4
Биет хөрөнгө	138,709,555.0	186,753,542.2
Биет бус хөрөнгө	14,290,385.8	15,864,199.2
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>484,882,828.0</b>	<b>679,407,971.3</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	24,258,668.2	31,528,912.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,534,504.1	18,914,846.7
Өглөг	1,262,782.5	1,460,971.2
Урьдчилж орсон орлого	20,271,721.6	17,453,875.4
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,724,164.1	12,614,066.2
Урт хугацаат зээл	2,724,164.1	12,614,066.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	460,624,159.9	647,879,058.4
Засгийн газрын хувь оролцоо	460,624,159.9	647,879,058.4
Засгийн газрын оруулсан капитал	50,327,827.0	62,889,747.2
Хуримтлагдсан үр дүн	373,549,180.6	544,344,023.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	36,747,152.2	40,645,288.1
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>484,882,828.0</b>	<b>679,407,971.3</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,263,259,725.5</b>	<b>4,085,327,646.0</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	129,133,583.0	225,222,521.5
Нийтлэг татварын бус орлого	129,133,583.0	225,222,521.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,134,126,142.5	3,860,105,124.6
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,158,838,185.7</b>	<b>3,872,707,805.3</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	<b>3,158,838,185.7</b>	3,872,707,805.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,092,225.0	247,292,250.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,245,448.1	150,939,606.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,768,774.8	18,450,157.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,497,402.6	9,539,247.7
Хангамж, бараа материалын зардал	3,962,586.1	6,404,253.7
Нормативт зардал	5,995,554.7	7,844,071.2
Эд хогшил, урсгал засварын зардал	1,098,992.4	2,246,881.1
Томилолт, зочны зардал	797,093.2	1,576,871.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,193,273.7	27,192,187.5
Бараа үйлчилгээний бусад зардал	16,533,099.4	23,098,974.4
ХҮҮ	0.0	0.0

ТАТААС	764,351,664.7	1,174,973,967.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,255,394,296.0	2,450,441,587.0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>104,421,539.8</b>	<b>212,619,840.7</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	691.0	1,496.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,164,221.3	25,670,886.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	96,258,009.5	186,950,451.0

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>363,327,442.6</b>	<b>363,327,442.6</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	977,504.6	977,504.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	364,304,947.2	364,304,947.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(34,981.8)	(34,981.8)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	96,185.0	96,185.0
Тайлант үеийн үр дүн	96,258,009.5	96,258,009.5
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>460,624,159.9</b>	<b>460,624,15.9</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	490,676.3	490,676.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,114,836.1	461,114,836.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(521,186.8)	(521,186.8)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	334,958.0	334,958.0
Тайлант үеийн үр дүн	186,950,451.0	186,950,451.0
<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>647,879,058.4</b>	<b>647,879,058.4</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,319,616,044.8</b>	<b>4,156,112,049.8</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	149,140,020.1	267,759,006.9
Нийтлэг татварын бус орлого	149,140,020.1	267,759,006.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,170,476,024.7	3,888,353,043.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,291,000,743.5</b>	<b>4,096,770,782.5</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	3,291,000,743.5	4,096,770,782.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	125,562,935.4	233,327,633.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,498,512.8	150,273,202.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,758,473.4	18,565,303.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,561,734.7	9,535,249.0
Хангамж, бараа материалын зардал	2,700,658.0	4,014,430.1
Нормативт зардал	6,254,373.5	8,514,500.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,222,976.0	3,074,448.8
Томилолт, зочны зардал	792,202.9	1,490,786.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,105,534.8	29,436,481.2
Бараа үйлчилгээний бусад зардал	3,668,469.5	8,423,231.2
ТАТААС	764,989,010.4	1,175,690,962.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,400,448,797.7	2,687,752,187.1
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>28,615,301.3</b>	<b>59,341,267.3</b>

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	21,919,143.0	38,660,259.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,919,143.0	38,660,259.6
Дотоод эх үүсвэрээр	21,919,143.0	38,660,259.6
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(21,919,143.0)</b>	<b>(38,660,259.6)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(19,999.1)</b>	<b>(9,594,417.5)</b>
Бусад эх үүсвэр	67.3	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	9,547,307.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	20,066.4	47,110.6
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>6,676,159.2</b>	<b>11,086,590.2</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,252,439.9	17,928,599.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,928,599.1	29,015,189.3

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,943,704,649,000.00</b>	<b>3,849,273,282,605.57</b>	<b>94,431,366,394.43</b>	<b>97.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,917,705,359,400.00</b>	<b>3,817,260,649,883.53</b>	<b>100,444,709,516.47</b>	<b>97.4</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>241,498,721,800.00</b>	<b>216,704,317,494.73</b>	<b>24,794,404,305.27</b>	<b>89.7</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>154,022,023,500.00</b>	<b>142,743,875,209.18</b>	<b>11,278,148,290.82</b>	<b>92.7</b>
Үндсэн цалин	80,353,810,900.00	76,086,693,822.68	4,267,117,077.32	94.7
Нэмэгдэл	45,707,854,000.00	39,073,014,747.91	6,634,839,252.09	85.5
Унаа хоолны хөнгөлөлт	13,911,600,900.00	14,735,452,400.33	(823,851,500.33)	105.9
Урамшуулал	14,023,701,000.00	12,780,875,676.24	1,242,825,323.76	91.1
Гэрээт ажлын хөлс	25,056,700.00	67,838,562.02	(42,781,862.02)	270.7
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,203,224,800.00</b>	<b>17,495,942,012.79</b>	<b>1,707,282,787.21</b>	<b>91.1</b>
Тэтгэврийн даатгал	13,146,287,500.00	12,051,389,587.35	1,094,897,912.65	91.7
Тэтгэмжийн даатгал	1,516,833,100.00	1,407,534,600.30	109,298,499.70	92.8
ҮОМШӨ-ний даатгал	769,805,600.00	716,266,062.90	53,539,537.10	93.0
Ажилгүйдлийн даатгал	747,010,400.00	644,661,310.03	102,349,089.97	86.3
Эрүүл мэндийн даатгал	3,023,288,200.00	2,676,090,452.21	347,197,747.79	88.5
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,524,797,800.00</b>	<b>9,376,342,407.07</b>	<b>1,148,455,392.93</b>	<b>89.1</b>
Гэрэл, цахилгаан	2,167,439,200.00	1,800,079,240.04	367,359,959.96	83.1
Түлш, халаалт	5,910,867,100.00	5,413,049,120.94	497,817,979.06	91.6
Цэвэр, бохир ус	1,124,430,100.00	868,946,009.22	255,484,090.78	77.3
Байрны түрээс	1,322,061,400.00	1,294,268,036.87	27,793,363.13	97.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,391,413,700.00</b>	<b>3,238,179,620.17</b>	<b>153,234,079.83</b>	<b>95.5</b>
Бичиг хэрэг	976,969,300.00	963,183,174.00	13,786,126.00	98.6
Тээвэр, шатахуун	681,669,600.00	614,786,733.45	66,882,866.55	90.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	489,144,000.00	440,559,067.84	48,584,932.16	90.1
Ном, хэвлэл	25,972,600.00	23,573,300.00	2,399,300.00	90.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,619,300.00	129,851,849.00	31,767,451.00	80.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,056,038,900.00	1,066,225,495.88	(10,186,595.88)	101.0
<b>Нормативт зардал</b>	<b>8,518,742,000.00</b>	<b>7,917,180,109.67</b>	<b>601,561,890.33</b>	<b>92.9</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,530,130,300.00	1,355,124,259.21	175,006,040.79	88.6
Хоол, хүнс	5,897,500,600.00	5,483,447,773.46	414,052,826.54	93.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,091,111,100.00	1,078,608,077.00	12,503,023.00	98.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,863,263,300.00</b>	<b>4,699,821,197.00</b>	<b>163,442,103.00</b>	<b>96.6</b>
Багаж, техник, хэрэгсэл	2,489,760,900.00	2,439,195,144.90	50,565,755.10	98.0
Тавилга	14,272,500.00	16,004,800.00	(1,732,300.00)	112.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	153,390,000.00	136,125,590.00	17,264,410.00	88.7
Урсгал засвар	2,205,839,900.00	2,108,495,662.10	97,344,237.90	95.6
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,242,944,000.00</b>	<b>1,108,837,629.56</b>	<b>134,106,370.44</b>	<b>89.2</b>
Гадаад албан томилолт	220,200,000.00	196,857,137.62	23,342,862.38	89.4
Дотоод албан томилолт	1,008,485,600.00	897,842,464.04	110,643,135.96	89.0

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Зочин төлөөлөгч хүлээн авах	14,258,400.00	14,138,027.90	120,372.10	99.2
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>36,919,926,400.00</b>	<b>27,731,260,770.30</b>	<b>9,188,665,629.70</b>	<b>75.1</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,007,315,700.00	26,179,612,275.27	8,827,703,424.73	74.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	257,711,700.00	204,910,000.00	52,801,700.00	79.5
Даатгалын үйлчилгээ	151,990,600.00	123,419,435.86	28,571,164.14	81.2
Тээврийн хэрэгслийн татвар	54,439,800.00	46,156,561.45	8,283,238.55	84.8
Тээврийн хэрэгслийн оношлогоо	5,247,300.00	3,312,620.00	1,934,680.00	63.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,026,606,300.00	996,758,628.70	29,847,671.30	97.1
Газрын төлбөр	77,042,000.00	60,463,291.00	16,578,709.00	78.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	23,286,800.00	15,988,858.02	7,297,941.98	68.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	316,286,200.00	100,639,100.00	215,647,100.00	31.8
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,812,386,300.00</b>	<b>2,392,878,538.99</b>	<b>419,507,761.01</b>	<b>85.1</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	1,938,789,800.00	1,575,038,303.30	363,751,496.70	81.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	873,596,500.00	817,840,235.69	55,756,264.31	93.6
<b>ТАТААС</b>	<b>1,175,691,517,800.00</b>	<b>1,175,691,512,299.96</b>	<b>5,500.04</b>	<b>100.0</b>
<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>1,175,691,517,800.00</b>	<b>1,175,691,512,299.96</b>	<b>5,500.04</b>	<b>100.0</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,175,691,517,800.00	1,175,691,512,299.96	5,500.04	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,500,515,119,800.00</b>	<b>2,424,864,820,088.84</b>	<b>75,650,299,711.16</b>	<b>97.0</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>9,420,874,000.00</b>	<b>9,419,058,389.34</b>	<b>1,815,610.66</b>	<b>100.0</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,243,687,000.00	9,242,897,636.12	789,363.88	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	177,187,000.00	176,160,753.22	1,026,246.78	99.4
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,491,094,245,800.00</b>	<b>2,415,445,761,699.50</b>	<b>75,648,484,100.50</b>	<b>97.0</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	34,809,663,900.00	34,809,663,900.00	-	100.0
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,350,539,614,800.00	2,299,000,426,655.54	51,539,188,144.46	97.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	669,626,700.00	639,961,838.21	29,664,861.79	95.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	94,012,024,400.00	70,716,862,833.00	23,295,161,567.00	75.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,032,816,100.00	2,347,985,696.27	684,830,403.73	77.4
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,549,895,600.00	7,477,192,924.48	72,702,675.52	99.0

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	480,604,300.00	453,667,852.00	26,936,448.00	94.4
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>48,758,104,600.00</b>	<b>35,465,325,772.76</b>	<b>13,292,778,827.24</b>	<b>72.7</b>
Барилга байгууламж	42,423,604,600.00	31,082,904,024.76	11,340,700,575.24	73.3
Их засвар	490,000,000.00	476,812,815.00	13,187,185.00	97.3
Тоног төхөөрөмж	5,844,500,000.00	3,905,608,933.00	1,938,891,067.00	66.8
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>(22,758,815,000.00)</b>	<b>(3,452,693,050.72)</b>	<b>(19,306,121,949.28)</b>	<b>15.2</b>
Эргэж төлөгдөх зээл	(22,758,815,000.00)	(3,452,693,050.72)	(19,306,121,949.28)	15.2
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,943,704,649,000.00</b>	<b>4,044,231,232,828.61</b>	<b>(100,526,583,828.61)</b>	<b>102.5</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,849,517,872,400.00</b>	<b>3,763,991,222,164.63</b>	<b>85,526,650,235.37</b>	<b>97.8</b>
Улсын төсвөөс санхүүжих	3,849,517,872,400.00	3,763,991,222,164.63	85,526,650,235.37	97.8
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,535,119,100.00</b>	<b>2,966,475,889.00</b>	<b>(431,356,789.00)</b>	<b>117.0</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,535,119,100.00	2,966,475,889.00	(431,356,789.00)	117.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>91,651,657,500.00</b>	<b>251,044,312,271.52</b>	<b>(159,392,654,771.52)</b>	<b>273.9</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,222,603,500.00	136,982,578,076.96	(106,759,974,576.96)	453.2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,426,669,000.00	12,799,780,292.54	(7,373,111,292.54)	235.9
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	56,002,385,000.00	101,261,953,902.02	(45,259,568,902.02)	180.8
<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-</b>	<b>26,229,222,503.46</b>	<b>(26,229,222,503.46)</b>	<b>-</b>
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	26,229,222,503.46	(26,229,222,503.46)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,509,163,926.25	(14,509,163,926.25)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	24,352,658,391.03	(24,352,658,391.03)	-
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>120</b>	<b>120</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	120	120	-	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>5,293</b>	<b>5,137</b>	<b>156.00</b>	<b>97.1</b>
Удирдах ажилтан	285	268	17.00	94.0
Гүйцэтгэх ажилтан	4,082	3,965	117.00	97.1
Үйлчлэх ажилтан	923	901	22.00	97.6
Гэрээт ажилтан	3	3	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>28,925,499,222.36</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>28,713,424,264.36</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>25,449,077,025.17</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>7,445,476,580.97</b>
Үндсэн цалин	-	1,311,739,808.82
Нэмэгдэл	-	4,985,565,071.48
Унаа хоолны хөнгөлөлт	-	138,187,984.00
Урамшуулал	-	814,786,828.57
Гэрээт ажлын хөлс	-	195,196,888.10
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>1,059,021,694.73</b>
Тэтгэврийн даатгал	-	843,695,093.60
Тэтгэмжийн даатгал	-	55,785,804.71
ҮОМШӨ-ний даатгал	-	32,697,359.35
Ажилгүйдлийн даатгал	-	23,098,860.27
Эрүүл мэндийн даатгал	-	103,744,576.80
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>203,644,991.03</b>
Гэрэл, цахилгаан	-	71,974,526.14
Түлш, халаалт	-	83,109,901.00
Цэвэр, бохир ус	-	21,038,363.89
Байрны түрээс	-	27,522,200.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>800,503,619.81</b>
Бичиг хэрэг	-	249,859,167.35
Тээвэр, шатахуун	-	237,826,980.20
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	43,346,895.26
Ном, хэвлэл	-	25,812,400.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	6,633,700.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	237,024,477.00
<b>Нормативт зардал</b>	-	<b>836,534,997.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	21,549,254.80
Хоол, хүнс	-	716,073,062.20
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	98,912,680.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>1,364,606,313.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	-	501,590,456.00
Тавилга	-	123,821,930.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	16,200,000.00
Урсгал засвар	-	722,993,927.00
<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>447,177,374.00</b>
Гадаад албан томилолт	-	12,104,900.00
Дотоод албан томилолт	-	435,072,474.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>7,114,918,664.49</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,074,291,158.49
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,209,600.00
Даатгалын үйлчилгээ	-	78,350.00
Тээврийн хэрэгслийн татвар	-	197,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	26,409,900.00
Газрын төлбөр	-	2,236,256.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	10,474,400.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>6,177,192,790.14</b>

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,690,181,368.07
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,487,011,422.07
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>3,264,347,239.19</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>1,729,700,233.34</b>
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	157,550,200.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	13,775,000.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	1,246,154,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	312,221,033.34
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>1,534,647,005.85</b>
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,512,924.37
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	34,023,844.71
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,485,095,411.63
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,014,825.14
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>212,074,958.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>212,074,958.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	212,074,958.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>28,925,499,222.36</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>28,925,499,222.36</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,344,506,739.38
ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,289,452,802.78
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,788,049,011.83
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,838,114,488.06
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	1,665,376,180.31
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 95,573.2 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 271 алдаа<sup>1</sup> илэрснээс 95,465.8 сая төгрөгийн 268 алдааг аудитын явцад залруулж, 107.3 сая төгрөгийн алдааг арилгах 3 зөвлөмж өгсөн.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 141,172.9 сая төгрөгийн 445 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 247.4 сая төгрөгийн 62 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 105,716.9 сая төгрөгийн 162 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,800.6 сая төгрөгийн 9 хариуцлага тооцох албан шаардлага, 32,260.9 сая төгрөгийн 204 зөрчилд зөвлөмж, 147.1 сая төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Залруулагдаагүй зөрчлийн нийт 141,172.9 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 107,488.9 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### 3.1 Эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд

ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 163 төсвийн захирагч нарын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 139 байгууллагад дүгнэлт гаргаж, 24 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитаар нийт 83,552.3 сая төгрөгийн 436 зөрчил<sup>3</sup> илэрснээс, 220.9 сая төгрөгийн 61 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 67,827.3 сая төгрөгийн 157 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,800.6 сая төгрөгийн 8 хариуцлага тооцох албан шаардлага, 12,556.3 сая төгрөгийн 202 зөрчилд зөвлөмж, 147.1 сая төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 102 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, “Хязгаарлалттай” 34 (ТТЗ-4, ТШЗ-30), “Сөрөг” 2 (Завхан аймгийн ГБХЗХГ, Баян-Өлгий аймгийн ХЭДСан), “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” 1 (Төв аймгийн ГБХЗХГ) дүгнэлт өгсөн.

“Хязгаарлалттай”, “Сөрөг” дүгнэлт болон “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” харьяа байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаанд анхаарч, нэгжийн дотоод хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

#### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч:

Аудитаар 19,332.5 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлж, 26.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, төсөвт байгууллагын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар 1 албан шаардлага, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 1 төсвийн төвлөрүүлэн захирагч, “Сөрөг” дүгнэлт авсан болон “Дүгнэлт өгөхөөс татгалзсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 19,306.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

##### 3.2.1. Төлбөрийн акт

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын бүрэн хэрэгжиж дууссан Сүхбаатар дүүргийн хүүхэд залуучуудын зуслан /УБ, НД/ 4,105.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний техник хяналтын зардлын 26.4 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-д “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

##### 3.2.2. Албан шаардлага:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 141,172.9 сая төгрөгийн 445 зөрчил илэрснээс, 247.4 сая төгрөгийн 62 төлбөрийн акт тогтоож, 105,716.8 сая төгрөгийн 162 албан шаардлага, 2,800.6 сая төгрөгийн 9 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 147.1 сая төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 32,260.9 сая төгрөгийн 204 зөвлөмж хүргүүлсэн, нийт залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн нь өмнөх оноос 1.9 дахин өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан гүйцэтгэх, харьяа байгууллагад илэрсэн зөрчлийг 20 хувь бууруулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.2.3. Хариуцлага тооцох албан шаардлага:

1.ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 121,840.0 сая төгрөгийн 54 хувь буюу 65,891.4 сая төгрөгийн ХЭДС-тай холбоотой бөгөөд өмнөх оноос зөрчлийн дүн 19,210.6 сая төгрөгөөр өссөн, өмнөх аудитаар өгсөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон нийт 18,053.8 сая төгрөгийн авлага барагдуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний хүрээний Завхан аймгийн ХГБХХГ, Баян-Өлгий аймгийн ХЭДС-ийн санхүүгийн тайланд "Сөрөг" дүгнэлт, Төв аймгийн ГБХЗХГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.1-т "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах;" гэж заасныг зөрчсөн, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, ...", 42.2-т "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн зарим албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй төсвийн төвлөрүүлэн захирагч, тайлант онд "Сөрөг" дүгнэлт авсан болон дүгнэлт өгөхөөс татгалзсан төсвийн шууд захирагч нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

### 3.2.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав.  
Үүнд:

Илрүүлэлт 1:

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 22,758.8 сая төгрөгийн эргэн төлөх төлбөрийн гүйцэтгэл 15 хувь буюу 3,452.6 сая төгрөг байгаа бөгөөд эх үүсвэрийг 19,306.1 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах; Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөр төлнө: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 22,758.8 сая төгрөг” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг бодитой, үндэслэлтэй төлөвлөж батлуулах, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах.

### **3.3. Түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил**

#### **3.3.1 ГБХНХЯ-ны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн данс:**

ХНХЯ-ны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн данстай холбоотой илэрсэн 229.5 сая төгрөгийн 1 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

#### **Албан шаардлага:**

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Сүхбаатар дүүргийн хүүхэд залуучуудын зуслан /УБ, НД/ 4,105.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гэрээний хугацаа дууссан төсөл арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 229.5 сая төгрөгийг Засгийн газрын 2023 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 456 дугаар тогтоолын хугацаа дуусгавар болсон байхад барьцаа хөрөнгийн дансанд хугацаа хэтрүүлэн байршуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2023 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 456 дугаар тогтоолын 1.3-т “төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хугацаа дууссан төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

#### **3.3.2 ГБХНХЯ-ы хөрөнгө оруулалт**

ГБХНХЯ-ны хөрөнгө оруулалтын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 38,057.8 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс 37,659.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2018 онд үүссэн аж ахуйн нэгжээс авах 398.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчилд зөвлөмж өгсөн.

#### **Албан шаардлага:**

Монгол улсын 2014 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд тусгагдсан нийт 17,240.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Олон улсын Найрамдал цогцолборийн "Усан спорт цогцолборын барилга"-ын төсөл арга хэмжээний санхүүжилтийн 91.0 хувь буюу 16,540.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгосон байна. Дээрх төсөл арга хэмжээний зураг төсөл зохиогчоос барилга нь зураг төсвийн дагуу баригдаагүй, чанарын шаардлага хангаагүй гэж дүгнэж зохиогчийн эрхийн хяналтаас татгалзах санал ирүүлсэн нь төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашиггүй зарцуулсан, цаашид өртөг нэмэгдэх эрсдэлийг бий болгосон байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;” 14.2.8-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах,” Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд

санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Удаашралтай байгаа барилгын ажлын гүйцэтгэлийг тогтоох, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах.

### **Албан шаардлага:**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2024 онд хэрэгжиж дууссан нийт 21,119.8 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, ажлын гүйцэтгэл дутуу, удаашралтай байна.

